

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙГМИЙН
САЛБАР, НОГООН ХӨГЖИЛ БОЛОН АГААР,
ОРЧНЫ БОХИРДЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ОРЛОГЧ, "НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН БАЯР-ХҮРЭЭ ЦАМ ДАНШИГ
НААДАМ 2025"-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА

А.АМАРТУВШИН

2025 оны 06 дугаар сарын 09

УДИРДАМЖ

2025 оны 06 дугаар сарын 09

Улаанбаатар хот

"НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН БАЯР-ХҮРЭЭ ЦАМ ДАНШИГ НААДАМ 2025"-ЫН ҮНДЭСНИЙ ИХ СУРЫН ХАРВАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нэг.Зорилго:

1.1. Үндэсний сурын харвааг хөгжүүлэх, харваачдын ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох, өв уламжлалыг олон нийтэд сурталчлан таниулах, залуу үеийнхэнд өвлүүлэхэд оршино.

Хоёр.Тэмцээний явагдах газар, хугацаа:

2.1. Үндэсний сурын харвааг 2025 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Хүй долоон худаг Монгол наадам цогцолборын үндэсний сур харвааны талбайд "Цуваа харваа"-ны төрлөөр зохион байгуулна.

2.2. Үндэсний сур харвааны бүртгэлийг 2025 оны 06-р сарын 25-ны өдрийн 18:00 цаг хүртэл google from-oop хаягаар хувь харваач бүртгэнэ. Лавлах утас: 88081625, 88656513

Гурав.Харваанд оролцох нөхцөл:

3.1. Үндэсний сурын харваанд аймаг, дүүргийн сурын салбар холбоо, клуб, баг, байгууллагын харваачид оролцно.

3.2. Үндэсний сур харвааг Монголын үндэсний харваачдын холбооны "Үндэсний их сурын харвааны дүрэм"-ээр зохион байгуулна.

3.3. Харваачийг согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно. Сур харвааны үед согтууруулах ундаа хэрэглэсэн харваачийг тэмцээнээс хасна.

Дөрөв. Үндэсний сур харвааны зохион байгуулалт, явагдах журам:

4.1. Тэмцээнийг Монголын Үндэсний Харваачдын Холбооноос томилсон

шүүгчийн бүрэлдэхүүн удирдан явуулна.

4.2. Ерөнхий шүүгч, нарийн бичгийн дарга, аж ахуйн шүүгч, хяналтын шүүгч, эмч шүүгч, самбарын шүүгч, зурхайн шүүгч нарыг Монголын үндэсний харваачдын холбооноос томилно.

4.3. Багийн ахлагч, дасгалжуулагч нар Үндэсний сурын харваагаар хичээллэгсэд, харваачдын аюулгүй байдлын заавар - №2016/02-тай багийн харваачдаа танилцуулан гарын үсэг зуруулсан байна.

4.4. Нийт харваачид энэхүү аюулгүй байдлын заавартай танилцсаны үндсэн дээр тэмцээнд орно.

Тав. Оноо тооцох журам:

5.1. Хана харваанд харвасан сум зурхайд тусаж хасааг унагаасан болон булцуу бүтэн сүлбэж гарсан тохиолдолд оноог тооцно.

5.2. Хасаа харваанд харвасан сум зурхайд тусаж хасааг унагасан тохиолдолд оноог тооцно. Сүлбэж гарсан сумыг оноонд тооцохгүй.

5.3. Харваач бүрийн хана харваанд харвасан 20 сум, хасаа харваанд харвасан 20 сумны нийлбэр оноогоор дүгнэж тэмцээний дүнг гаргана.

5.4. Оноо тэнцвэл товх харваж хожлыг шийдвэрлэнэ.

Зургаа. Бай шагнал:

6.1. Цуваа харваанд нийлбэр дүнгээр эрэгтэй, эмэгтэй эхний 10 байр залуулна.

- 1 дүгээр байр алтан медаль, өргөмжлөл, 8,000,000.00₮
- 2 дугар байр мөнгөн медаль, өргөмжлөл, 6,000,000.00₮
- 3 дугаар байр хүрэл медаль, өргөмжлөл, 4,000,000.00₮
- 4 дүгээр байр хүрэл медаль, өргөмжлөл, 3,000,000.00₮
- 5 дугаар байр хүрэл медаль, өргөмжлөл, 2,000,000.00₮
- 6 дугаар байр өргөмжлөл, 1,000,000.00₮
- 7 дугаар байр өргөмжлөл, 800,000.00₮
- 8 дугаар байр өргөмжлөл, 600,000.00₮
- 9 дүгээр байр өргөмжлөл, 400,000.00₮
- 10 дугаар байр өргөмжлөл, 200,000.00₮ тус тус шагнаж урамшуулна.

"НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН БАЯР-ХҮРЭЭ ЦАМ ДАНШИГ НААДАМ 2025"-ЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ